



22140601



International Baccalaureate®
Baccalauréat International
Bachillerato Internacional

MONGOLIAN A: LITERATURE – HIGHER LEVEL – PAPER 1
MONGOL A : LITTÉRATURE – NIVEAU SUPÉRIEUR – ÉPREUVE 1
MONGOL A: LITERATURA – NIVEL SUPERIOR – PRUEBA 1

Friday 9 May 2014 (morning)

Vendredi 9 mai 2014 (matin)

Viernes 9 de mayo de 2014 (mañana)

2 hours / 2 heures / 2 horas

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a literary commentary on one passage only.
- The maximum mark for this examination paper is [20 marks].

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire littéraire sur un seul des passages.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est [20 points].

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario literario sobre un solo pasaje.
- La puntuación máxima para esta prueba de examen es [20 puntos].

Доорх хоёр зохиолын аль нэгийг сонгон уран зохиолын талаас тайлбарлаж бич:

1.

Сайн цагийн мянган бурханаа мөргөмүй. Эрт урьд зургаан зүйл хамаг амьтны эх болсон, илэрхий зөөлөн авирт, илт хурдан тонилгогч Ногоон Дар эх Яншин сүмд Дүнжин гарвын хийдэд арван наснаас далан долоон нас хүртэл хатуужил даяаныг бясалган суув. Даяаны үндсийг дүүргээд зургаан зүйл хамаг амьтны эх болсон 5 илэрхий зөөлөн авирт, илт хурдан тонилгогч Ногоон Дар эх дээд сайн цагийн мянган бурхан, Шигэмүни бурхан, Очирваани бурхан огторгуйн түмэн хуврагуудын оронд дээш нисэн өөд болов. Мянган бурханы орныг гурван үе эргэж мөргөөд: “Би Яншин сүмд Дүнжин гарвын хийдэд арван наснаас далан долоон нас хүртэл хатуужил 10 даяаныг бясалган суув. Урьдах минь холдож, хойтох минь ойртож, эдүгээ ганцаар тул над нэг үр заяа!” гэж хутаг гүйсанд сайн цагийн мянган бурхан зургаан сайн эмийг адислан өгөв. Тэр эмийг зооглосны сүүлд ерэн есөн насан дээр нь Очирвааниас 15 үндэстэй, ургамал наран мэт өнгөтэй улаан бимбийн (тоорын жимс) уруултай, өндөр Бирузана мэт тэгш сайхан биетэй, хас эрдэнэ мэт шүдтэй, галбарвасун мод мэт нуруутай, бодтой бурханы дүртэй Оюу нэртэй бодьсад хөвүүн төрөв. Тэр хөвүүнийг 20 бадам лянхуа цэцэгт хучиж, элдэв зүйлийн жимсийг шимүүлэн байтал гурван хоногийн сүүлд хөвүүн үгүй болон одов. Тэр Ногоон Дар эхийн дэлгэр сайхан цорой нь дээш эвхтэл татав. Бадрангуй саруул цээж нь балар харанхуй болж, бат төвшин сэтгэл нь долгисон дайвалж, юмчин цагаан хөх нь ширгэн хатав. Саран цагаан царай нь харлаж, сайхан зандан хөл нь сөхөрч, алтан амаар шороо үмхэн унаад 25 дээр тэнгэрийг дэнсэлтэл, доор газрыг донсолтолтой уйлж, хувхай модноос навч цэцэг ургатал, хонхор газар ус тогттол хайлав. Тэр цагт дээд сайн цагийн мянган бурханы орноос Шигэмүни бурхан өөд болон ирээд баруун мутраас нь дээш татаж аваад 30 гурван үе сургаал тавиад дээш нисэн өөд болов.

Зургаан зүйлийн хамаг амьтны эх болсон илэрхий зөөлөн авирт, илт хурдан тонилгогч Ногоон дар эх алтан жигүүртэй, мөнгөн сүүлтэй бор эрээн харцгай болон хувилж, дээш мянган бурханы оронд нисэн өөд болоод мянган бурханыг гурван үе эргэж мөргөөд “Би Яншин сүмд Дүнжин гарвын хийдэд арван наснаас далан долоон нас хүртэл хатуужил даяаныг бясалган суув. Даяаны үндсийг төгсөөд сайн цагийн мянган бурханы оронд хүрч “Эдүгээ би ганцаар тул над нэг үр заяа!” гэж айлтгасанд 35 ерэн есөн насан дээр минь ургасан наран мэт өнгөтэй, улаан бимбийн уруултай, өндөр Бирузана мэт тэгш сайхан биетэй, хас эрдэнэ мэт шүдтэй, галбарвасун мод мэт нуруутай, бодтой бурханы дүртэй, Оюу нэртэй бодьсадва минь үгүй болон одов. Сайн заяатай агсан болвоос мянган бурханы оронд шавь болон төрсөн болов уу гэж санаад ирэв. Гагцхүү төрсөн бодьсадва хөвүүнийг минь үзэв үү?” хэмээн мэдүүлсэнд “Авай, зургаан зүйлийн хамаг амьтны эх болсон Ногоон дар эх минь чиний гагцхүү төрсөн бодьсадваг чинь үзсэнгүй” гэв. Тэр цагт “Хойт мөрт зар тавихын тул бэлгэ тэмдгийг айлтганам. Зүрхний эхэнд таван зуун цогцын бэлгэ бүрдсэн бэх хар мэнгэ буй билээ. Хоёр далны хооронд сувдын дүрээр бүтсэн шүр улаан мэнгэ буй билээ.

- 40 Тийм болохул миний хөвүүн магад мөн” гэж зар тавиад доор замбутивд бууж, арван найман тамын амьтанд төрсөн болов уу гэж ирээд мөн тамын амьтнаас “Гагцхүү төрсөн Оюу бодьсадваг минь үзэв үү?” гэж асуув. Төдий тамын амьтан: “Авай, зургаан зүйлийн хамаг амьтны эх болсон Ногоон Дар эх минь! Чиний гагцхүү төрсөн Оюу бодьсадваг чинь бид үзсэнгүй” гэв. Мөн Ногоон Дар эх арван найман тамын амьтны аливаа зовлонг арилгаад замбутивийн дээр хоёр хөлт хүн, дөрвөн хөлт адгуусанд төрсөн болов уу гэж тэр амьтнаас бас асуув. Тэд амьтан бас “Үзсэнгүй” гэв.
- 45

Зохиогч нь тодорхойгүй, *Ногоон Дар эхийн тууж* (1995)

2.

- Уран соёмбот тугаа орой дээрээ мандуулж
 Улаан тугийн дуугаа уриан сүртэй нийлүүлж
 Улайран довтлогчийг урvasан дайсантай нь давхар цохиж
 Улс үндсээ сэргээн босгосон ард түмэн минь.
- 5 Эрин үеийн эрхэм сайхны босго алхаж
 Энэрэлт төрийнхөө эрдэнэт баганыг тулан баталж
 Эх орныхоо голомтыг хувьсгалын галаар асаалаа
 Эрх чөлөөнийхөө үүдийг цагийн сайнаар нээлээ.
 Дайнд ядарсан морьдын хөл нуруу нь амарсаар
- 10 Дайтаж явсан эрсийн хүсэл зориг нь биелсээр
 Даяар нутаг минь хөрөнгөт нийгмийн толгой дээгүүр
 Далай даян нийгэм журмыг зорин алхлаа.
 Аз жаргалаа гартаа авсан улс оронд минь
 Аж амьдралаа төвхнүүлэх лут ээлж тулгарлаа
- 15 Аав ээжийнхээ гал голомтыг би ч сэргээж
 Айлын дайтай айл болох сэтгэл төрлөө.
 Хорин хоёр онд журамт цэргээсээ халагдаад
 Хотол хошуундаа ирж аравны дарга хийснийхээ
 Хойтон жил нь гэргий авч гэр барихаар шийдээд
- 20 Хоньчин айлын бүсгүйтэй аж амьдралаа хол болоо.
 Нэг бие хоёр болгоод өөдрөг ч байлаа
 Нимгэн дэвсгэрээ зузаан болгоод өнгөтэй ч байлаа
 Нийлж суусан тэр жилийн хавар эхнэр маань
 Нэг өдөр “бие шалтагтай” гэж надад хэллээ.
- 25 Хүү ч төрнө үү, охин ч төрнө үү, ямар ч гэсэн
 Хүүхэдтэй болох нь дээ, бид хоёр гэж баярлаад
 Хөдсөн өлгий, хүйн боолтоос эхлээд би чинь
 Хөнгөрч амаржихад хэрэгтэй бүхнийг нь бэлдэж төхөөрлөө.
 Авгай маань тэгээд л өвлийн сүүл сард амаржаад
- 30 Алаг нүд нь тормолзсон хөөрхөн охин төрлөө
 Аав эжийдээ цэцэг болсон охинд минь нэг өвгөн
 Амарзаяа гэдэг нэр хайрлан өгч билээ.
 Энд тэнд ажлаар яваад гаднаа буухад
 Эх хүний бүүвэйн дуу гэрт минь уянгалаад
- 35 Энхрий охины минь нарийхан дуу өхөөрдмөөр дуугарч
 Эгшигт хөгжмийн уяхан ая шиг сонсдох боллоо.
 Хүн төрөлхтний ёстой амьд бурхан юм чинь
 Хүсэл сэтгэлийг татагч аялгуу сайт хөгжим юм чинь
 Хүндэтгэн үзэх хамгийн дээд сор нь юм чинь
- 40 Хүүхдээ хайрлахгүй эцэг эх хаа байх вэ.

Ч.Лхамсүрэн, Хурандaa (1961)